

# БУЛЬДОГ ШИГ ИТГЭЛ

ХЭЗЭЭ Ч ТАВИЛГҮЙ, ТАС ЗУУ!



*Мэрилин Хикки*

# БУЛЬДОГ ШИГ ИТГЭЛ

ХЭЗЭЭ Ч ТАВИЛГҮЙ, ТАС ЗУУ!

Мэрилин Хикки

---

BULLDOG FAITH: How to Hold on & Never Let Go  
(Mongolian) by Marilyn Hickey  
Copyright © 1986  
by Marilyn Hickey & Sarah Bowling

Marilyn Hickey Ministries  
[www.marilynandsarah.org](http://www.marilynandsarah.org)

Originally published in English as  
BULLDOG FAITH: How to Hold on & Never Let Go  
ISBN 978-1-938696-10-7

БУЛЬДОГ ШИГ ИТГЭЛ: Хэзээ ч тавилгүй, тас зуу!  
Мэрилин Хикки  
© 2018, Marilyn Hickey

Библийн ишлэлийг: АРИУН БИБЛИ  
© 2004, 2011, 2013  
Ариун Бичээс Нийгэмлэг

Монгол улсад хэвлэв

## **ИТГЭЛ БОЛ ШИРҮҮН ТУЛААН**

Хэзээ ч давж гарахгүй мэт санагдах эгц өөд мацсаар явна уу? Асуудлаа бараг л шийдчихлээ гэж бодтол дараагийн том асуудал өмнө чинь дүнхийж харагдана уу? Тийм үед л чөтгөр тан руу дайрна. Харин та “бульдог” итгэлээр өөдөөс нь ураад хаядаг юм шүү.

Бульдог бол дайчин, зодоонч нохой. Өрсөлдөгчөө доороо оруулаад нэг зуугаад авбал, тавихгүй, тас зууна. Өөрөө үхсэн ч, зууснаа тавихгүй.

Та бид Бурханы Үгээс тас зуурч бүх хүчээрээ ялалтын төлөө зүтгэх ёстой. “Бульдог” шиг гүрийж, Бурханы үгээс тас зуурч, дайснаа ялах хүртлээ, нөхцөл байдлаа өөрийн болготлоо итгэлээр амьдрах ёстой.

Дайчин, ширүүн тулаанч байхын тулд итгэл найдвараа Бурханд тавих ёстой.

Зарим хүн: “Чөтгөр итгэгчдээс их айдаг” гэж хэлдэг л дээ. Гэхдээ энэ бол алдаатай, буруу ойлголт. Хэрэв сатан биднээс айдаг юм бол яагаад энэ олон итгэгч ялагдаж амьдардаг билээ? Тэр та биднээс айдаггүй, харин түүнийг ар дагзаар нь савтал унагах “бульдог” итгэлээс л айдаг юм.

Сатан юуны түрүүнд бидний итгэлийг хулгайлахыг зорьдог. Бид итгэлээ алдвал ялагдаж, сатан ялна. Бид заримдаа: “Чөтгөр миний эрүүл мэндийг”, “... амар тайвныг” хулгайлахыг оролддог гэж ярьдаг. Гэхдээ эдгээр нь том хулгайн дэргэд өчүүхэн хулгай юм. Чөтгөрт бидний итгэл л хэрэгтэй. Тэр бидний итгэлийг цөлмөх гэж л довтолдог. Тиймээс “бульдог” нохой соёогоо нэг л шигтгээд авсан бол, тас зуудаг шиг та бид Бурханы Үгээс байдаг хүчээрээ тас зуух ёстой юм. Тэгж чадвал дайсан ялагдаж, та бид ялна!

## ҮГД ИТГЭХ

Хэрвээ та ялгуусан амьдралаар амьдрахыг үнэхээр хүсч байвал, Бурханы Үг л танд ялах стратеги өгдөг гэдгийг үргэлж санаж яваарай.

“Итгэлийн сайн тэмцлээр тэмц. Мөнх амийг зуур. Чи үүнд дуудагдсан бөгөөд олон гэрчийн өмнө сайн гэрчлэл хийсэн” (1Тимот 6:12).

Итгэлээр алхана гэдэг нь Бурханы Үгд итгэж, тэр Үгээр амьдрахыг хэлнэ. “Тиймээс итгэл нь сонсохоос, сонсох нь Христийн үгээр ирдэг” (Ром 10:17) гэсэн ишлэлд “сонссон” гэж өнгөрсөн цаг дээр биш, харин “сонсох” хэмээн одоо цаг дээр хэлжээ. Өөрөөр хэлбэл, Үгийг өдөр бүр, дахин дахин сонсох ёстойг онцложээ.

## **ИТГЭЛ БОЛ ХҮЧИРХЭГ ЗҮЙЛ**

Есүс та биднийг сатаны эрх мэдлээс салгасан ч, бидэнд хамаатай жижиг сажиг зүйлсийг чөтгөр хулгайлахыг санаархсаар байдаг. Харин та бид Христийн хүч чадлаар дайсантай хийх эцсийн тулаанд “бульдог” итгэлээр ялалт байгуулна.

“Харагтун, могой ба хилэнцэт хорхойнуудад халдах, дайсны хамаг хүчээс дээгүүрх эрх мэдлийг Би та нарт өгсөн. Та нарт юу ч хор учруулахгүй” (Лук 10:19).

Дайсны хамаг хүчээс дээгүүрх, дайсанд халдан довтолох хүчийг Есүс итгэгч нарт өгсөн. Харин бид ийм эрх мэдэлтэйгээ ухаарч, зоригтой байх ёстой. Хэрэв бид эрх мэдлээрээ байх аваас, бидний амьдралд халдах гэсэн дайсны ёрын муу хүчтэй тулж, ялах болно:

“Бурханаар төрсөн бүхэн ертөнцийг ялдаг. Ертөнцийг ялсан ялалт нь бидний итгэл болой. Есүс бол Бурханы Хүү гэж итгэдэг хүнээс өөр хэн ертөнцийг ялагч байх вэ?”  
(1Иохан 5:4-5)

Амьдралд тулгарч болох ямар ч эсэргүүцэл бидний итгэлийг давахгүй гэдгийг та ойлгож байна уу? “Яахав Библи тэгж хэлдэг л дээ” гэж үү? Тийм ээ, Библи үнэн хэлдэг. Та бид итгэлээр аврагдсан, итгэлээр амьдарч байгаа мөн итгэлээр энэ ертөнцийн хамаг муу муухайг ялан дийлдэг. Итгэл бол хүчирхэг зэвсэг, итгэл бол таны ялалт.

## **ИТГЭЛ ХАМГИЙН ЧУХАЛ ЗҮЙЛ**

Бүхнээс чухал нь итгэл. Бурхан биднээс хамгийн түрүүнд итгэлийг маань л хардаг. Бурхан танд нигүүлслээ өгсөн ч, танд итгэл байхгүй



бол, тэр нигүүлслийг хүлээн авч чадахгүй. Аврагдах эсэх нь итгэлээс л хамаарна. Ром 10:10 үүнийг батладаг:

“Хүн зүрхэндээ итгэн зөвт байдалд хүрч, амаараа хүлээн зөвшөөрч авралд хүрнэ.”

Алив зүйлийг хийхээс өмнө та бид эхлээд итгэх ёстой. Тиймээс ИТГЭЛ НЭГДҮГЭЭРТ орно!

Би итгэлийг нэгдүгээрт тавихдаа магтаал хүндэтгэл, залбирал, дуулгавартай байдал тэргүүтэй итгэгч хүний амьдралын бусад чухал юмсыг үгүйсгэх гэсэнгүй. Зүгээр л эдгээрийг итгэл манлайлдаг юм. Тиймээс л итгэлийг ойлгож, чухалчилж, онцлох ёстой. Ром 1:17-г харцгаая:

“«Зөвт хүн итгэлээр амьдарна» гэж бичигдсэнтэй адилаар, Бурханы хүртээх зөвт байдал нь сайнмэдээний дотор итгэлээс итгэлд

илчлэгддэг.”

“... Итгэлээс итгэлд ...”

Ямар хүчирхэг тунхаглал вэ! Бүрэн төгсөөр, бүхнийг багтаажээ! Итгэлээр зөвт байдлыг хүлээн авна - тэгээд итгэлээр үүрд мөнхөд амьдарна.

## **ИТГЭЛ БОЛ ТЭНГЭРИЙН НАЙДВАР**

“Итгэл бол найддаг зүйлсийн маань бодит байдал, харагдахгүй зүйлсийн баталгаа мөн” (Еврей 11:1).

Бурхан итгэлийг “найддаг зүйлсийн маань бодит байдал” гэжээ. Зарим хүн: “Найдаж байхад бүх юм болно доо” гэж хэлдэг л дээ. Гэхдээ найдвар нь өөрөө бодит байдал биш, харин итгэл нь бодит байдал юм. Итгэл, найдвар хоёрын ялгааг харцгаая.

Шинэ хувцастай болохсон гэж найдаж байна гэж бодъё. Тэгээд тэр хувцсаа авахыг хүснэ. Тэр хувцсаа авчихсан, өмсчихсөн явж байна гэж төсөөлнө. Тэр хувцастай каталог, сэтгүүл үзнэ. Гэхдээ энэ найдлага маань надад тэр хувцсыг авч өгөх үү? ҮГҮЙ!  
Найдвар тээлээ гээд хүсэл биелэхгүй. Найдвар бол ердөө л зорилго өгдөг. Харин итгэл тэрхүү зорилгыг бодитой болгодог.

Живж буй хөлөг онгоцонд яваа хүн: “Онгоц минь живчихгүй байгаа даа” гэж хэлбэл, энэ нь ердөө л хүслийнх нь зорилго болно. Зүгээр л ингэж найдснаар живж буй онгоцыг аврах уу? Аз сорьсон л хэрэг болох байх. Найдлага тавьснаар хөлөг онгоц аврагдахгүй. Гэхдээ Бурханы өгдөг итгэл бидний амьдралд бодит зүйлийг бий болгодог. Бид найдвар дээрээ итгэлээ нэмэх хэрэгтэй. Итгэл тань тэнгэрт хүрээд: “Энэ бол найддаг зүйлийн баталгаа” гэж хэлдэг.

Тэгвэл бидэнд зориулагдсан “бодит” тусламж тэнгэрт байгааг яаж мэдэх вэ? Бурханы Үг хэлсэн учраас, бид итгэх ёстой. Хэрэв би “Миний Бурхан алдар дахь баялгаараа Христ Есүс дотор та нарыг хэрэгтэй бүхнээр чинь хангана” (Филиппой 4:19) гэдгийг Библиэс олж мэдээгүй байсан бол, Бурхан материаллаг хэрэгцээг маань бодитоор хангаж чаддагийг бас л мэдэхгүй явах байсан. Хэрэв би “Есүс миний нүглийг үүрч, Түүний шархаар би эдгээгдсэн” гэж Библиэс уншаагүй байсан бол, тэнгэрт миний төлөө хадгалагдсан эдгэрэлд итгэхгүй байсан. Хэрэв хүн Библид бичигдсэн Бурханы амлалтыг эхлээд олж мэдэхгүй бол, тэнгэрт буй бодит тусламжийг итгэлээрээ хүлээн авах боломжгүй юм.

Жишээ нь: Библи дээр Бурхан “Сайныг хайгч нэгэн ивээл тааллыг олно” (Сургаалт үгс 11:21) гэж амлажээ. Үүнийг мэдсэнийхээ дараа

би үр хүүхдийнхээ авралын төлөө итгэвэл, Бурхан аварна гэдгийг ойлгосон юм.

Танд аврал, эдгэрэл - ер нь юу л хэрэгтэй байна - тэдгээр нь тэнгэрт бодитоор бидний төлөө хадгалагдаж байдаг. Тэдгээрийг зөвхөн итгэлээр л хүлээн авах боломжтой.

## **ИТГЭЛ БОЛ БУРХАНЫ ДУРТАЙ “СУВАГ”**

Бурханы өгөх гэсэн тэдгээр бодит ивээлийг итгэлээс өөр сувгаар хүлээн авах гэвэл бүтэлгүйтнэ. Хэрэв би зөвхөн нүдээр харсандаа л итгэбэл, тэр ч бас буруу суваг болно. Жишээ нь: 9-ээр сувгаар гардаг нэвтгүүлгээ 7-аар сувгаар үзэж чадах уу? Мэдээж үгүй! Итгэлийн хувьд ч ийм л зарчим үйлчилдэг. Бид бүх долгионоо Бурханы суваг болох итгэл дээр л тааруулах хэрэгтэй.

Хүмүүс голдуу буруу сувгаар  
Бурханаас тэмдэг, долгион хүлээн  
авах гэж хүлээдэг. Ихэнх итгэгчид  
буруу сувагт бүх анхаарлаа  
хандуулснаасаа болоод асуудалд  
ордог. Дашрамд хэлэхэд, итгэл  
бидний логикийг давдаг. Бид Бурханы  
хангамжийг таван мэдэрхүйнхээ  
сувгаар хүлээн авахыг хүсэхдээ адаг  
сүүлд нь гонсойж хоцордог.

Бид бүхнийг таван мэдэрхүйгээрээ  
хүлээн авч ойлгох гэвэл, итгэл  
таныг сэтгэл гонсгор, ойлгомжгүй  
байдалд оруулна. Итгэлийг зургаа  
дахь мэдэрхүй гэж хэлж болох юм.  
Энэ бол онцгой, сүнслэг мэдэрхүй.  
Бидний мэдэрч болох бүхнээс давсан  
мэдэрхүй гэж ойлгож болно.

Бид таван мэдэрхүйнхээ логик ухаан,  
нөхцөл байдлаа давж, Бурханы  
Үгд итгэх ёстой. Биднийг итгэлээр  
залбирч эхлэх үед л Бурхан хэрэгцээг  
маань хангадаг. Бурхан яаж ажиллаж

байгааг бид заримдаа хардаггүй ч,  
Тэр ажилладаг:

“Тийм учир Би та нарт хэлье. Та нар  
юуны төлөө залбиран гуйна, түүнийгээ  
авсан гэдэгтээ итгэгтүн. Тэгвэл тэр  
чинь ёсоор болно” (Марк 11:24).

Нүдэнд харагдахгүй ч, Бурхан бидний  
төлөө ажилласаар байдаг. Үүнд л  
итгэлийн нууц оршино. Залбирсан  
зүйлээ хүлээн авсан гэдэгтээ итгэхийг  
л Бурхан биднээс хүсдгийг Библи  
хэлдэг. Бид залбирчихаад: “Би харж  
байж л итгэнэ” гэж хэлж болохгүй.

Тиймээс ОДОО итгэ! Итгэл биднээс  
яг ОДОО итгэхийг шаарддаг. “Итгэл  
бол бодит ... харагдахгүй зүйлийн  
баталгаа” гэж хэлснийг санаж байна  
уу? “Бол” гэж одоо цаг дээр ярьж  
байгаа биз? Итгэлийг өнгөрсөн юмуу  
ирээдүй цаг дээр бус, одоо цаг дээр  
ярьдаг. Итгэл маргаашийг хүлээлгүй,  
яг одоо итгэдэг. Итгэлээр бид

залбирч байгаа зүйлээ авсан гэдэгтээ шууд итгэдэг. Бурханы Үг доторх амлалтад тэр даруй итгэж, юу ч харагдахгүй байгаа ч, тухайн зүйлээ бодитоор хүлээн авсан гэдгээ мэдэх нь итгэл юм.

## **ИТГЭЛЭЭР БУРХАНЫ ТААЛЖЫГ ХҮРТДЭГ**

Бурханд хэрхэн таалагдах вэ? Итгэлээр! Еврей 11:6 дээр “Итгэлгүйгээр таалагдах боломжгүй...” гэдэг.

Бурханд таалагдахыг хүсвэл, Түүний Үгд итгэлээр хандаарай. Бурхан хүртэл итгэлийг таалдаг гэхээр итгэл ямар чухал болохыг ойлгож байна уу? Та тэнгэрлэг итгэгч байж болох ч, итгэлгүй бол Бурханд таалагдахгүй. Бурханы тодорхой Үгийн төлөө Бурханд итгэж байвал, Бурхан таныг таалж, итгэлийг чинь шагнана.



Зарим итгэгчид идэвхи зүтгэлээрээ Бурханд таалагдаж болно гэдэг заль мэхд дөнгүүлдэг. Тэд: “Би өдөрт 5 цаг залбирч, Библиэс өдөр бүр 59 бүлэг уншиж, чуулгандаа явсаар байвал, Бурхан намайг лавтайяа таална” гэдэг. Мэдээж чуулгандаа явж, Библиэ унших нь зөв. Гэхдээ Бурхан бидний идэвхи зүтгэлийг бус, Бурханы Үгд итгэх итгэлийг л онцлон таалдаг.

Тэгвэл яаж итгэх вэ? Залбирахдаа Бурхан намайг сонсоно гэж итгэ. Библи дээр “Учир нь Бурханд ойртон буй нь Тэр байдаг гэдэгт ... итгэх ёстой” гэсэн. Тиймээс: “Хэрэв Бурхан ямар нэг юм хийвэл, би итгэх болно” гэж бүү хэл. Бурханд болон Түүний Үгд бат итгэ. “Юу ч өөрчлөгдөхгүй байгаа юм чинь Бурхан гэж байдаггүй юм байна” гэж бүү хэл. Еврей 11:6-аар ишлэлийн төгсгөлд “... Өөрийг нь хайгчдад Тэр Шагнагч нь болдог гэдэгт итгэх ёстой” гэдэг.

## **ИТГЭЖ БАЙГАА БОЛ ХИЧЭЭН ЗҮТГЭ**

Итгэл биднээс хичээл зүтгэлийг болон зориулалтыг шаарддаг. Бурхан байдаг гэдэгт итгэдэг бол, Түүнийг хичээнгүй эрэн хайх ёстой. Бурхан тийм хүмүүсийг л шагнадаг.

Хэрэгцээ чинь хангагдахгүй юу? Яалаа гэж, заавал хангагдана! Харин Библидээ арван дөрөв хоног тутамд ганц удаа салхи оруулдаг бас олигтой залбирдаггүй хүнийг ямар хичээл зүтгэлтэй гэх билээ? Сард хоёр удаа л ажилдаа ирдэг бүтэн цагийн ажилтныг ямар хүн гэх үү? Хичээл зүтгэлтэй гэх үү? Эсвэл өдрийн 8 цаг ажиллах ёстой хүн 3 цаг л ажилладаг бол, түүнийг хичээл зүтгэлтэй гэх үү? Түүний цалинг нэмэх үү? Үгүй л болов уу. Хичээл зүтгэлгүй хүн шагнуулахгүй. Тэгвэл газрын энэ зарчим тэнгэрт ч хэрэгжинэ.

Хэрэв та бид Эзэний замаар хайнга амьдардаг бол, Түүнээс бүтэн ерөөл авч чадахгүй. Библи хичээл зүтгэлийг өндрөөр үнэлдэг. Самуел итгэлдээ хичээл зүтгэлтэй хүн байсан. Түүний хичээл зүтгэлийн үр шимийг бид өнөөдөр ч хүртдэг. Итгэлд нэгэн гайхамшигтай чанар бий. Юув гэхээр - итгэлтэй хүн өөрөө өөд болсон ч, итгэлийнх нь үр шим удаах үед нь нөлөөлсөөр байдаг. Самуел ээжийнхээ аугаа итгэлийн үрээр л аугаа итгэлийн хүн болжээ. Итгэл нь итгэлийг тэтгэдэг.

Нэгдүгээр Самуел номын эхэнд Ханна, Пенинна гэдэг хоёр эхнэртэй Елкана гэдэг эр гардаг. Пенинна нь үр хүүхэдтэй, харин Ханна нь хүүсэр байв. Тэдний харилцаа ч нэг их аятайхан байсангүй. Пенинна юм л бол Ханнаг: “Нойтон сормуустай амьтан тэвэрч үзээгүй” хэмээн тавлаж, тамладаг байв.

Ханна ч мөчөөгөө өгөөгүй л байх. Учир нь Ханна хүүхэд төрүүлээгүй ч, нөхөр нь түүнийг Пениннагаас илүү хайрладаг байсан гэж Библи хэлдэг. Тиймээс Пениннагийн хорон үгийн хариуд Ханна: “Тийм ээ, чи хүүхэд төрүүлээ л биз. Гэхдээ нөхөр маань надад илүү хайртай” гэдэг байсан биз. Итгэгч хүн ийм байвал, тун тоогүй!

## **ИТГЭЛ БОЛ НӨХЦӨЛ БАЙДЛЫГ ӨӨРЧЛӨГЧ**

Ханна аятайхан хандлагатай байгаагүй байж болно. Гэхдээ түүнд нөхцөл байдлаа өөрчлөх нэг хүчин зүйл байсан нь итгэл байв!

Ханна хүүхэд төрүүлж чадахгүйдээ үнэхээр гутарч байсан ч, Өөрийнхөө хүмүүсийг өсгөн үржүүлэх Бурханы амлалтад итгэж байв. Тэр үед хүүхэдгүй эмэгтэйг хараагдсан гэж үздэг байжээ. Гэхдээ Ханна Бурханд итгэв!

Хожим Елкана Бурханд тахил өргөж, хүндэтгэхээр Шило руу гэр бүлээ дагуулаад явдаг. Тэр үед Ханна синагогт ороод, хүүхэдтэй болохын төлөө уйлан хайлан залбирчээ:

Библи дээр:

“Үртэй уутаа үүрэн уйлан цааш нааш явах тэрээр багцалсан тариагаа үүрэн баяр хөөрийн дуутай гэртээ ирнэ” (Дуулал 126:6) гэдэг.

Тэгвэл Ханна Бурханы Үгийн үрийг барьсаар, нулимс унаган залбирсан юм.

Дан нус нулимсаар Бурханыг уяраахгүй л дээ. Бурхан биднийг өрөвдсөндөө хөдлөхгүй. Харин Бурханы Үгийг барин, Түүн рүү уйлан хайлан хадах залбирал Бурханы сонорт хүрч, хөдөлгөдөг.

“... Эзэн ... дагалдах тэмдгүүдээр үгийг баталсаар байлаа. Амен” (Марк 16:20).

Бурхан өрөвдсөндөө туслах уу? Үгүй!  
Өдөржингөө: “Би Танд гомдож байна.  
Ёстой муухай!” гэж хашгирсан ч, Бурхан  
хариулахгүй! Бурхан Өөрийнх нь Үгд  
итгэсэн итгэлийн залбиралд л хариулна!

## **ИТГЭЛ БОЛ ЕРТӨНЦӨӨС Ч ХҮЧТЭЙ, ЕРТӨНЦӨӨС Ч ТОМ**

Ханна: “Бурхан минь, би эмэгтэй  
хүн учраас үр хүүхэд хүсч байна.  
Та надад хүү заяагаач. Тэгвэл би  
тэр хүүг Танд өргөх болно” гэж  
залбирсан юм. Тэр үед сүмийн тахилч  
Ханнад: “Одоо харь. Бурхан чамд үр  
хүүхэд заяаг” гэжээ. Жилийн дараа  
Ханна хүүтэй болов. Тэгж Бурханы  
“Нулимстайгаар үрээ таригчид нь  
ургацаа хураан авч баяр хөөртэй  
болно” гэсэн үг биелжээ.

Ханна гайхамшгаар төрсөн хүүдээ  
“Бурханаас гуйсан” гэх утгатай  
Самуел гэдэг нэр хайрлажээ. Ханна

хүүгээ Бурханаас өгсөн онцгой бэлэг гэдгийг насан турш санаж явахын тулд ийнхүү нэрлээ байх. Ертөнцийн хуулиар бүтэх боломжгүй зүйлийг Бурхан Ханнагийн итгэлээр бүтээн, хүүхэд төрүүлэх боломжгүй түүнд үр хүүхэд заяажээ. Итгэл бол ертөнцийн хамаг хүчээс аугаа билээ.

“Бурхан чамд үр хүүхэд заяаг” хэмээн Ханнаг ерөөсөн тэр тахилч нь хожим Самуелийн асран хамгаалагч болсон Ели байв. Ели хэдийгээр сүнслэг хүн байсан ч, Самуелийг өсгөхөд арай л зохисгүй хүн байв. Учир нь тэрбээр хоёр хүүгээ хүмүүжүүлж чадаагүй байлаа. Хоёр хүү нь Бурханы тахилын хамаг л тарган сайхныг хулгайлдаг, завхай явдалтай хүмүүс байв. Би л байсан бол: “Бурхан минь, яахаараа Ели байдаг билээ?” хэмээн дуу алдах байсан.

Гэхдээ Самуел Елигийн хоёр хүүгээс тэс өөр хүн болдог. Ханнад “Бурхан

бүхнийг хянадаг бөгөөд итгэл нь энэ дэлхийгээс аугаа!” гэсэн итгэл байжээ.

## **ДЭЭЛ МЭТ ИТГЭЛ**

Ханна жил бүр хүүгээ эргэж ирэхдээ, шинэ дээл оёж авчирдаг байжээ. Бил хувьдаа Ханнагийн итгэл нь яг тэр дээл хувцас шиг хүүг нь хамгаалдаг байсан гэж итгэдэг. Таны итгэл ч бас хайртай хүмүүсийг чинь дээл мэт ороон хамгаалдаг. Итгэл нь өмсч, тээдэг хүмүүсээ хамгаалдаг учраас, ямар ч нөхцөл байдлыг бут цохидог.

Нэг шөнө Самуелийг сүмд унтаж байтал, ЭЗЭН түүнийг “Самуел ээ!” хэмээн хоёр ч удаа дууджээ. Самуел багшийгаа дуудлаа гэж бодоод, багш дээрээ гүйж очтол, багш нь: “Би чамайг дуудаагүй, явж унт” гэдэг. Гэтэл гурав дахь удаагаа Самуелийг багш дээрээ хүрч ирэхэд, багш Ели



нь: “Чамайг ЭЗЭН дууджээ. Дахиад дуудбал: “ЭЗЭН минь, Таны зарц сонсож байна” гэж хэлээрэй” хэмээн заагаад явуулжээ.

ЭЗЭНийг дахин дуудах үед Самуел заалгасан ёсоороо үйлдэж, анх удаа ЭЗЭНий Үгийг сонсжээ. Та: “Пөөх, ёстой догь!” гэх байх. Гэхдээ Самуелийн сонссон үг нь багшийнх нь гэр бүлийн ирээдүйд хамаатай, таагүй үг байсан юм. ЭЗЭН Самуелд “Ели хөвгүүдээ ЭЗЭНээс дээгүүр тавьсан учраас, гал голомт нь сүйрч, үйлчлэл нь тасарна. Харин Самуел Елиг залгамжлах тахилч болно” гэсэн утгатай үг хэлжээ.

Бод доо! Самуелээс өмнө гагцхүү Аароны удмынхан л Бурханд тахилчаар үйлчилдэг байв. Гэтэл Самуел Аароны удмын хүн биш боловч, ээжийнхээ итгэлээр тахилч болжээ.

## **ИТГЭЛ ТА БИДНИЙГ ДЭВШҮҮЛДЭГ**

Таны итгэл ч бас таныг Самуел шиг дэвшүүлж, “Чам шиг хүн ингэдэггүй юм” гэмээр өндөрлөгт гаргана. Сургууль завсардсан юмуу тааруухан сурлагатай байсан хүмүүс Бурханы Үгээс зуурч, “БУЛЬДОГ ИТГЭЛЭЭР” амьдарсныхаа ачаар нэр нөлөө бүхий улс төрч, хүчирхэг бизнесийн хүн болохыг миний бие олонтаа харсан. Итгэл та биднийг хүний ухаанаар ойлгомгүй арга замаар жирийн нөхцлөөс ер бусын нөхцөл рүү дагуулдаг. Самуел удам угсаа талаасаа хэзээ ч тахилч болох боломжгүй байсан ч, итгэлээр болжээ.

Бурханы дуу хоолойг сонссон Самуел Ели дээр очоод: “Та үхнэ, танай хоёр хүү ч үхнэ. Тиймээс өвөө минь, зайгаа тавиад өг. ... Одооноос би шинэ тахилч боллоо!” гэж хэлээгүй.

Харин Бурхан өөрөө хийх хүртэл Самуел багш Елийгээ өрөвдөн хайрласаар байжээ. Бурхан тогтоосон цагтаа итгэлтэй хүнийг дэвшүүлдэг. Самуел ч Бурханы цаг хугацаанд өөрийгөө даатгажээ.

Тахилч болсныхаа дараа ч Самуел ард олондоо өр зөөлөн ханддаг байлаа. Тэр үеийн Израилийн тэргүүн тахилч гэдэг төр, шашныг хослуулан барьдаг, тэргүүн дээд эрхтэн байсан юм. Самуел сайн удирдагч байсан ч, ард түмэн түүнийг эсэргүүцдэг байв. Энэ үед Самуел өөрийгөө дэвшүүлэх гэж итгэлээ ашиглаагүй, харин хүмүүст тэвчээртэй ханддаг байлаа.

## **ИТГЭЛ БИДНЭЭС ТЭВЧЭЭРТЭЙ БАЙХЫГ ШААРДДАГ**

Ихэнх хүн хайр бол амьдралын хамгийн чухал зүйл бөгөөд итгэл нь хайраар л амилдаг гэдэг. Мэдээж

тийм. Гэхдээ хайр ч итгэлээр амилдаг. Самуелийг эсэргүүцсэн шиг хүмүүс амьдралд зөндөө таарна. Бид тийм хүмүүсээс зайгаа аваад: “Өөө! Эднийг хэн ч хайрлаж чадахгүй!” гэж хэлэх үү? Гэхдээ итгэл бидэнд хамгийн адгийн новшийг ч хайрлахад туслана! Бид тийм хүмүүстэй хүссэн хүсээгүй учирна. Тийм хүмүүсийг байлдан дагуулахад, тонн тонн итгэл хэрэгтэй.

Ард түмэн Самуел дээр ирээд: “Бидэнд та хэрэггүй. Бид бусад улс шиг хаантай болмоор байна. Тан шиг шашин, төрийг хослуулан баригч удирдагч бидэнд хэрэггүй!” гэж хэлжээ. Та бод доо. Хамаг амьдралаа зориулсан хүмүүс чинь: “Та бидэнд хэрэггүй!” гэж хэлбэл ямар байх бол?

Тэгвэл Самуел яасан? Самуел: “Бурхан минь, тэд намайг голчихлоо” гэж боддог. Тэр хүний мэдэрхүйгээр л ханджээ. Тэр өөрийгөө өрөвдөж, ард түмэнд гологдсондоо гутарсан.

Харин бид яах байсан бол? Магадгүй: “Ингэж үйлчлээд ямар ч ашиг алга!” гэх байсан биз. Ингэбэл Бурханы маш том ерөөлийг алдана. Харин итгэлээр бат явбал эцэстээ ялна.

Бурхан Самуелд өөрийгөө өрөвдөхийг зөвшөөрөөгүй. Бурхан түүнд: “Самуел ээ, тэд чамайг биш, Намайг голж байгаа юм. Жаахан тэвч. Тэдний хүссэн хааныг удахгүй томилно” гэж хэлдэг.

Үнэхээр ч Самуел удалгүй Саулыг хаанаар томилж, томилсон хааныхаа эрх мэдэл дор үнэнчээр амьдардаг (Самуел итгэл, тэвчээрийнхээ ачаар амьдралаа сайн дуусгасныг бид хардаг). Самуел хаандаа үнэнч байсан боловч, хаан нь биеэ тоосон хүн байжээ.

Саул хаанд нэг том дутагдал байсан нь тэрбээр хүнээс айдаг байв. Айдас бол итгэлийн эсрэг зүйл. Нэг удаа Израильчууд Филистинчүүдтэй тулалджээ. Тулааны өмнө Самуел тахил

өргөх ёстой байсан ч, цагаасаа хоцров. Тэр үед Саул тэвчээр алдаж: “Цаашид хүлээж чадахгүй нь. Бид давших ёстой. Давшихгүй бол ялагдана!” гэжээ. Тэгээд Саул айсандаа яаран хөдлөж ялагдсан юм. Тэрбээр дур мэдэн өөрийн биеэр тахил өргөхдөө, Бурханыг уурлуулжээ. Дараа нь Бурхан Самуелаар Саулд: “Чиний хаанчлах хугацаа дууслаа” гэж хэлүүлсэн юм.

Хожим Саул хаан дахиад л Бурханы урмыг хугалжээ. Бурхан Амалекчуудыг газрын хөрснөөс арчихыг тушаасан байтал Саул хагас дутуу биелүүлсэн юм. Саул ашиггүй санагдсан хүмүүсээ алсан атлаа ашигтай санагдсан хаад, тарган мал сүргийг амьд үлдээжээ. Самуел Саулын энэ гэмийг нүүрэн дээр нь илчилж, Амалекийн хаан Агагийг дуудуулсанд Агаг: “Үхэл ард хоцорлоо” гэж хэлдэг. Гэтэл Самуел: “Чи сэлэмнийхээ ирээр олон бүсгүйг хүүхэдгүй болгож байсныхаа хариуд өнөөдөр эх чинь тэдгээр үр хүүхэдгүй

эмэгтэйчүүдийн нэгэн адил болно” гэж хэлээд, амь гарлаа хэмээн онгирсон Агагийг шууд алдаг.

Саул хаан хожим залуу Давидад атаархаж дайсагнадаг. Учир нь Давид Филистины аварга баатрыг ялжээ. Яагаад атаархах болов? Нөгөө л итгэлийн эсрэг зүйл болох айдсаасаа болж тэр!

Эцэст нь Саул дайны үеэр Израиль ялагдахыг мэдээд, босоо сэлэмдээ сүлбүүлж амиа хорлодог. Саул зөндөө алдаа гаргасан ч, Самуел түүнд эцсээ тултал үнэнч байсан юм. Тиймээс Бурхан түүнийг хоёр ерөөлөөр ерөөжээ: (1) Самуел Израилийн хамгийн мундаг хаан Давидыг тослон томилсон; (2) Самуел эш үзүүлэгч нарын залгамж халааг төрүүлж, энэ залгамжлалаас Исаиа, Иеремиа, Езекиел, Елиа тэргүүтэй Хуучин гэрээний аугаа эш үзүүлэгч нар төрсөн юм. Өнөөдөр бид тэдгээр эш үзүүлэгч

нарын номыг уншихдаа, Самуелийн итгэлийн үр шимийг л хүртдэг.

## **ИТГЭЛ БОЛ БОДИГ ҮЙЛДЭЛ**

Самуелийн итгэл урт настай, жинхэнэ итгэл төдийгүй, юунаас ч үл айх, зоригтой итгэл байжээ. Самуел аминд нь халтай байсан ч, элэг доог болсон ч, Бурханы хүслийг итгэлээр зоригтой үйлддэг байв. Өнөөдөр ч байдал ийм байна. Өнөөдөр итгэгчид бид Бурханы хүслийг сөрсөн үг яриа, нөхцөл байдалд амьдарч байна.

Хүмүүс: “Хэрвээ итгэгчид л улс төрд идэвхитэй оролцвол ...”, “Хэрвээ итгэгчид л багшилбал ...”, “Хэрвээ итгэгчид л зориглон хөдөлбөл ...”, “Хэрвээ итгэгчид л залбирч, зуучлан гуйвал ...” гэж ярьдаг.

Хүн бүр л итгэгчид ингэх тэгэх ёстой гэдэг. Тэгвэл Бурхан юу



хэлнэ вэ? Бурхан Үгдээ хэлсэн итгэлээ л батладаг. Итгэгчид байнга алдаад байгаа нь юуных вэ? Бид яагаад үсэрч наалдаад юм хийхгүй байна? Итгэгчид олон юм ярихаа болиод зүгээр л хийж эхлэбэл, юмс өөрчлөгдөж эхлэнэ!

Бид бүхнийг хүссэн шигээ онцсайн хийхгүй байлаа ч, Бурханы Үгд итгэж амьдарвал, бидний чадахгүйг Үг хийнэ. Есүс: “Ургац хураахад бэлэн болжээ. Тиймээс ажилчдыг гуй” гэж хэлсэн. Эзэнд үйлчлэх ажилчид цөөрсөн талаар бүү ярь. Харин олон болохын төлөө залбир. Өөрөө тэдний нэг бай! Итгэлээр ажиллаж байгаа биднийг юу ч зогсоохгүй.

## **ИТГЭЛИЙГ ОЙЛГОХ НЬ**

Өмнө намайг “итгэл хүний логикоос давсан зүйлийг хийдэг” гэж хэлэх үед та: “Мэрилин, танаас ийм үг гарахаар

хачин юм даа” гэж бодсон байх. Гэхдээ итгэлийн 2 түлхүүр чанарыг харах хэрэгтэй:

- Бурханд таалагдаж, ер бусын амьдралаар амьдрахад та бидэнд итгэл хэрэгтэй.
- Таван мэдэрхүйгээс давсан ер бусын ертөнцөд амьдрахад та бидэнд итгэл хэрэгтэй. Харах, үнэрлэх, амтлах, хүрэх, сонсох гэсэн таван мэдэрхүйн хязгаараар Бурханыг бүү хэмж. Итгэл нь таван мэдэрхүйг давсан хүчээр ажилладаг.

Есүс Христэд итгэж, Түүний цусны хүчээр цагаатгуулж, бодол санаагаа шинэчилж, сүнсээр төрсөн хүнд итгэл ирдэг. Энэ итгэл нь Бурханы амлалт Үг дээр суурилдаг. Бурханы өмнө зөв зүрх сэтгэлтэй яваа итгэгч хүн итгэлээр хүлээж авсан Үгээ Есүс Христийн нэрээр тунхаглаж, Үг түүний төлөө юу хийхийг итгэлээр харах хэрэгтэй.

Ийм итгэл таныг ер бусын ертөнц рүү оруулдаг. Ийм итгэл соёогоо Бурханы амлалтад зоогоод “Надад зориулсан зүйл тэнгэрт байгаа!” гэж хэлдэг.

Тэгээд итгэсэн зүйл чинь харагдах үед - харагдаж, үнэртэж, амтлагдаж, баригдаж, сонсогдох үед л та итгэлийг ойлгоно! Та “бульдог” шиг итгэлээр тэнгэрийн ерөөлийг газарт буулгадаг.

Танд бульдогийн итгэл шиг амин чухал зүйл байхгүй. Бурхан ч танд үүнийг л хүсч байгаа. Тиймээс зуур, бүү бууж өг! Ялалтын төлөө урагшаа! Нөхцөл байдал дундаа Бурханы Үгд соёогоо зоогоод, ялан ялтлаа зуу!






- Илгээлтийн төсөл
- Хоол хүнсний хөтөлбөр
- Өнчин, орон гэргүй хүмүүст зориулсан халамжлийн үйлчлэл.



# ҮГЭЭР АМЬДАР... ГАЙХАМШГИЙГ ТАЙЛ



Энэ бол Мэрилин, Сара хоёрын дуудлага. Биеийн болоод сүнслэг хэрэгцээний төлөө үйлчлэх нь Мэрилин Хиккигийн үйлчлэлийн зүрх юм.



Мэрилин Хиккигийн охин Сара Боулинг, нөхөр Рииз Боулингийн хамт.



Дэлхий даяарх  
эдгэрлийн  
үйлчлэл болон  
Сургалтын  
төвүүд...



- Библи • Христигэлт утга зохиол • 1500 гаруй төрлийн үйлчлэл • Бидэнтэй [marilynandsarah.org](http://marilynandsarah.org) цахим хаягаар холбогдоно уу.



- Дэлхий даяар цацагддаг зурагтын хөтөлбөр
- Цахим хуудас
- Залбирлын сүлжээ
- Илгээлтийн аян





**БИДЭНТЭЙ ДАРААХ  
ЦАХИМ ХАЯГААР ХОЛБОГДОНО УУ:**

**[marilynandsarah.org](http://marilynandsarah.org)  
[savingmoses.org](http://savingmoses.org)**

# БУЛЬДОГ ШИГ ИТГЭЛ

ХЭЗЭЭ Ч ТАВИЛГҮЙ, ТАС ЗУУ!

Бурханы Үгд соёогоо зоогоод - наранд ч  
бороонд ч, живсэн ч сэлсэн ч - ялан ялтлаа  
зуудаг ялагч нар л хамгийн аз жаргалтай  
Христэд итгэгч нар мөн!

Энэ бол **БУЛЬДОГ ШИГ ИТГЭЛ**. Энэ бол муу  
бүхнийг сөрөх итгэгчдийн зуудаг итгэл!  
Энэ бол ялалтад хүргэх итгэл!

Мэрилин энэхүү мөнхийн үнэ цэнэтэй  
сургаалаараа танд **БУЛЬДОГ ШИГ ИТГЭЛЭЭР**  
чөтгөрийг сүүлээ хавчаад зугттал нь хазаад  
өгөхийг заадаг.

**БУЛЬДОГ ШИГ ИТГЭЛЭЭ** хэрэглэ!



“Мэрилин Хикки Министрийз”  
үйлчлэлийн үндэслэн байгуулагч  
бөгөөд ерөнхийлөгч Мэрилин маань  
Бурханы Үгийг даян дэлхийд  
түгээсээр явна. Түүний Библийг  
заах үйлчлэл нь зурагт, хиймэл  
дагуул, ном, CD, DVD, эдгэрлийн  
үйлчлэлээр дамжуулан олон улсад  
хүрдэг.